

**МОНГОЛЫН ГАДААД ОРЧИН ДАХЬ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
БОЛЗОШГҮЙ ТӨСӨӨЛЛҮҮД /POSSIBLE SCENARIOS¹/***Ч.Сосорбарам**

Даяаршил, мэдээллийн эрин үе улс хоорондын хамаарлыг нэг улсын хил доторхи оршин суугчдаар хязгаарлахгүйгээр бүс нутаг, тив дэлхийн хэмжээнд хүргэж, дайн хүчирхийллийн асуудал, түүнд бэлтгэх төлөвлөх явдлыг ч өөрөөр үзэхэд хүргэж байна. Манай орон ч гэсэн олон тулгуурт гадаад харилцааны төрийн бодлогоо тодорхойлон идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна.

2004 онд байгуулагдсан шинэ засгийн газрын мөрийн хөтөлбөрт “Зэвсэгт хүчний чадавхийг хөгжүүлэх урт болон дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөтэй болно” гэж заасан билээ.

Батлан хамгаалах бодлого, ялангуяа түүний нэг гол хэсэг болсон зэвсэгт хүчнийг хөгжүүлэх бодлого, стратегийг төлөвлөхдөө олон улсын аюулгүй байдал, аюул заналхийллын ирээдүйг харсан төсөөллийг тооцсоны үндсэн дээр хийдэг. Товчхондоо тухайн улсын үндэсний ашиг сонирхолд ирээдүйд учирч болзошгүй ямар аюул заналхийлэл байна гэдгээс зэвсэгт хүчний (ЗХ) үүрэг зориулалт нөхцөлдөж, эдгээрийн үндсэн дээр ямар чадавхитай зэвсэгт хүчин байх, түүнийг хэзээ, хэрхэн бий болгох, хэрхэн шинэчлэх вэ гэдгийг тооцсон тодорхой төлөвлөгөө төсөл боловсруулах асуудал, зүй ёсны шаардлага өнөөгийн цаг үеийн нөхцөл байдлаас урган гарч байна.

Улс орны ашиг сонирхол, түүнд учруулж болох аюул заналхийллыг хөгжилтэй орнуудад² хэрхэн төсөөлж “болзошгүй төсөөлөл /сценари/”-ийг хөгжүүлдэг аргачлалыг өөрийн орны нөхцөлд зохицуулан авч үзье.

Төсөөлж байгаа хугацаанд /10-20 жилд/ манай орны аюулгүй байдал, эрх ашигт нөлөөлөх олон улсын “байж болзошгүй” орчны хувилбарууд:

1. АНУ өөрийн хүчин чадлыг бүс нутагт хадгалсаар байх,

а. ОХУ болон БНХАУ өөрийн дотоод тогтвортой байдлыг хадгалахын зэрэгцээ өөрийн нөлөөллийн бүсийг бий болгосон байх,

б. ОХУ өөрийн дотоод тогтвортой байдлыг хадгалахын зэрэгцээ өөрийн нөлөөллийн бүсийг бий болгохоор үргэлжлүүлэн оролдсоор байх, БНХАУ дотооддоо тогтворгүй,

в. ОХУ дотооддоо тогтворгүй, БНХАУ өөрийн дотоод тогтвортой байдлыг хадгалахын зэрэгцээ өөрийн нөлөөллийн бүсийг бий болгохоор үргэлжлүүлэн оролдсоор байх,

¹Ч.Сосорбарам - БХЯ-ны Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа

г. ОХУ болон БНХАУ дотооддоо тогтворгүй,

2. АНУ өөрийн хүч нөлөөг тухайн бүс нутагт алдсан байх,

а. ОХУ болон БНХАУ өөрийн дотоод тогтвортой байдлыг хадгалахын зэрэгцээ өөрийн нөлөөллийн бүсийг бий болгосон байх,

б. ОХУ өөрийн дотоод тогтвортой байдлыг хадгалахын зэрэгцээ өөрийн нөлөөллийн бүсийг бий болгохоор үргэлжлүүлэн оролдсоор байх, БНХАУ дотооддоо тогтворгүй,

в. ОХУ дотооддоо тогтворгүй, БНХАУ өөрийн дотоод тогтвортой байдлыг хадгалахын зэрэгцээ өөрийн нөлөөллийн бүсийг бий болгохоор үргэлжлүүлэн оролдсоор байх,

г. ОХУ болон БНХАУ дотооддоо тогтворгүй гэх мэтчилэн цааш нь үргэлжлүүлбэл лалын орнууд, хоёр Солонгосын хүчин зүйлүүдтэй холбогдсон тоо томшгүй олон цагийн байдлын хувилбарууд гарч ирнэ.

Манай орны хувьд хамгийн эрсдэлтэй орчинг АНУ өөрийн хүч нөлөөг тухайн бүс нутагт алдсан байх, ОХУ суларч доройтон БНХАУ өөрийн нөлөөллийн бүсийг манайхыг тойруулан бий болгосон байх явдал /2г/ гэж үзэж болно. Энэ талаар Хантингтоны “соёл иргэншлийн мөргөлдөөний” онол, Фрийдманы “даяаршлын хөгжлийн хандлага”, Хятад, ОХУ-ын уламжлалт “монгол хөзөр”, Баабар, Баярхүү нарын “хэт космополитон үзэл” зэрэг ирээдүйн олон улсын харилцааг төсөөлсөн төрөл бүрийн таамаглалууд байдаг бөгөөд эдгээр нь бусад олон хүчин зүйлүүдийн харилцан шүтэлцээтэй уялдан манай ирээдүйг тодорхойлох биз ээ.

Эдгээрээс хамгийн байж болох орчиныг сугалан авч, сценари хөгжүүлэхэд ашигладаг ажээ. Энэ нь манай орны хувьд:

Төсөөлж байгаа хугацаанд АНУ өөрийн хүчин чадлыг хадгалсаар байх, ОХУ болон БНХАУ өөрийн дотоод тогтвортой байдлыг хадгалахын зэрэгцээ өөрийн нөлөөллийн бүсийг бий болгохоор үргэлжлүүлэн оролдсоор байх явдал гэж үзлээ.

Энэ тохиолдолд Монгол Улсын аюулгүй байдлын зорилт зарчмын хувьд урьдын адил буюу эдийн засгийн харьцангуй биеэ даасан болон байгаль орчны тогтвортой хөгжил рүү чиглэсэн хэвээр байх болно.

Их хоёр хөрштэйгээ болон барууны орнуудтай харилцах харилцааны тэнцвэртэй байдал амин чухал асуудал. Олон улсын харилцааны шинэ орчин Монголд илүү боломж олгож байгаа хэдий ч Монголын улс төрчдөөс илүү уян хатан, прагматик бодлого явуулахыг шаардаж байна. Монгол Улс мэдээллийн эрин зуунтай маш амжилттай холбогдох, хөл нийлүүлэн алхах ёстой.

Ингээд олон улсын хамгийн байж болох дээрх орчинд нөлөөлөх аюул заналхийллын болзошгүй сценарийг дараахь байдлаар /сургуулийн хэлбэрээр/ авч үзье.

Нэгдүгээрт. Авилгал, хээл хахууль, улс төрчдийн туйлшрал, бодлогогүй үйлдэл, зарим хөршийн шууд болон шууд бус далд нөлөөлөл зэргээс үүдэн Монголын ардчилал сулран замхарч, төр улс нь хүчин мөхөсдөж дотоодын эмх замбараагүй байдал /failed or failing state/ үүсч болзошгүй юм. Энэ тохиолдолд улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд гадаад, дотоодын сөрөг нөлөөллийн уршгаар аминд тулсан аюул занал /АМЮ/ учирна. Жишээ нь: Үүнийг далимдуулан тус улсын газар зүйн байрлалаас үүдэн цэргийн хүчээр журам дэг тогтоох нэрийн доор тодорхой улсын цэргийн хүчин орж ирэх магадлал өндөр юм. Иймд Монгол Улсад ардчилсан ертөнцтэй илүү ойр харилцаатай байж, ялангуяа НҮБ, АНУ, ЕХ, Японы дэмжлэгт тулгуурлах нь амин чухал ашиг сонирхол /АА/ байх юм. Зэвсэгт хүчин энэ үед хүмүүнлэгийн чадавхи буюу сургалт сэтгэл зүйн бэлтгэлтэй, иргэний хяналтын төлөвшсөн тогтолцоотой байх ёстой.

Ерөнхийдөө Монгол Улсын язгуур ашиг сонирхол, онцгойлон хэлбэл эдийн засгийн харьцангуй бие даасан байдал, экологийн тогтвортой хөгжил нь Монголоос өөрөөс нь түүний дотор төрийн удирдлагын чадавхи, хүний хөгжил, ардчиллыг хөгжүүлж байгаа байдлаас ихээхэн хамаарна. Үндэсний аюулгүй байдал нь үндсэндээ нийгэм, улс төр, эдийн засаг, цэрэг-дипломатын аргаар болон олон улсын хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлэх замаар хангагддаг.

Хоёрдугаарт. Оросын эдийн засгийн задран уналт, дотоодын тогтворгүй байдал, улс төрийн экстремист шийдлүүд нь Орост зэвсэгт мөргөлдөөн гарахад хүргэж болзошгүй. Монголын хоёр хөршийн тэнцвэртэй байдал сулрах бөгөөд Хятад энэхүү Оросын сулрах байдлыг ашиглахыг хичээж, өөрийн нөлөөгөө ихэсгэх болно. Тува болон Буриадаас их хэмжээний энгийн иргэд Монгол руу дүрвэн орж ирэх зэрэг нөхцөл, шалтгаан үүсч ч магадгүй.

Мөн Монгол Улс нь Оросын нефтийн бүтээгдэхүүний хомсдолоос болж үүсэх эдийн засгийн хүндрэл бэрхшээлтэй тулгарна. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зорилго нь эдийн засгийн асуудал ба улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах асуудал руу чиглэгдсэн байх зайлшгүй шаардлагатай.

Хүснэгт №1 Болзошгүй сценари–Possible scenarios /сургуулийн хувилбар/

	Аюул заналхийлэл хүндрэлийн хэлбэр	Аюул ын зэрэг	ЗХ-ний оролцоо	Гадаад талын үүрэг, оролцоо					
				НҮБ	АНУ	ОХУ	БНХАУ	ЕХ	Япон, Энэтхэг
1.Монголын өөрийн алдаа	Тусгаар тогтнол	АМЮ	Бага	АА	?	?	?	?	?
2. Оросын эдийн засгийн задрал	Дүрвэгсэд, Эдийн засаг, Хил	Ю	чухал	ЧА	?	?	?	?	?
3. Хятадын улс төрийн задрал	Дүрвэгсэд, Эдийн засаг, Хил, цэрэг	Ю	Их	ЧА	?	?	?	?	?
4.Орос, Хятадын тогтворгүй байдал	Дүрвэгсэд, Эдийн засаг, Хил, цэргийн	НЮ	чухал	ЧА	?	?	?	?	?
5. АНУ-ын тусгаарлах бодлого	Улс төрийн	НЮ	бага	ЧА	?	?	?	АА	?
6. Олон улсын алан хядлага	Улс төрийн	НЮ	бага	Д	?	АА	АА	?	?

Товчилсон үгийн тайлбар:

Монголын хувьд учрах аюул заналхийлэлийн хэлбэрүүд:

- АМЮ–аминд хүрсэн аюул,
- ИЮ – их аюултай ,
- Ю–аюултай,
- ЮУ- аюул бага буюу аюулгүй

Монголын ашиг сонирхол:

- АА амин чухал;
- ЧА –чухал;
- Д- дамжсан,
- З– зайлсхийх

Ингэж Оросын нөлөө бүс нутагт сулрах байдал, нөгөө талаар Хятадын хүчирхэг байдал өсөн нэмэгдэх үед хоёулантай нь найрсаг хэвийн харилцаатай байх зорилт нь Монголын эрх баригчдаас ихээхэн ур ухаан ажиллах эрч хүчийг шаардах болно. Энэ нь манай улсаас АНУ, ЕХ, Япон болон НҮБ-тай улс төр, эдийн засаг, цэргийн талаар аль болох ойр дөт харилцааг хөгжүүлэх, зохистой батлан хамгаалах төсвийг нэмэгдүүлэхийг зүй ёсоор шаардана.

Гуравдугаарт, Хятадын улс төрийн задралт, эдийн засгийн уналт, дотоодын тогтворгүй байдал, болзошгүй иргэний дайн зэргээс улбаалан Монгол руу их хэмжээний дүрвэгсэд орж ирэх магадлалтай. Ерөнхийдөө Монгол Улсын үндэсний язгуур эрх ашиг нь улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдал мөн. Эдгээр нь илүү хүчирхэг

батлан хамгаалах төсөв болон НҮБ, АНУ, ЕХ, ОХУ-тай цэргийн харилцааг хөгжүүлэхийг шаардаж болно.

Эцэст нь Монголын хувьд хамгийн эрсдэлтэй аюулгүй байдлын орчин бол Оросын эдийн засгийн уналт болон Хятадын улс төрийн задрал зэрэг тохиолдож энэ үед бүс нутагт дэг журам тогтоох талаар ганцаардаж, хүчин мөхөсдсөнөөсөө болж АНУ “зай барин өөрийгөө тусгаарлах” шинэ бодлого баримталж болзошгүй явдал юм. /4,5 хоёр нийлсэн сценари/

Энэ үед Монгол Улсад эдийн засаг, улс төр, цэргийн аюул нүүрлэх магадлал ихэснэ. Энэхүү аюулгүй байдлын орчны төсөөллөөр бол, Монгол нь нефтийн бүтээгдэхүүний хомсдолд орж, эдийн засаг, улс төрийн бусад хүндрэл бэрхшээл, тогтворгүй байдал, цэргийн мөргөлдөөнөөс үүдэн гадаадад их хэмжээгээр цагаачлах явдалд өртөж болох юм. Энэ нь чадварлаг, юуны өмнө энхийг сахиулах болон бусад төрөл бүрийн үүрэг гүйцэтгэх чадвартай ЗХ, түүний бэлтгэлийг хангахуйц төсөв хөрөнгө шаардана.

Эдгээрийг шийдвэрлэхэд Монгол Улс нь НҮБ, барууны орнуудтай ойр дотно харилцаатай байхыг нилээд чухалчлах нь зайлшгүй.

АНУ-ын өөрийгөө тусгаарлах болзошгүй бодлого гэдгийг тодруулахын тулд АНУ-ын их стратегийн хувилбаруудыг авч үзье. /Хүснэгт №2/³

Энэхүү хүснэгтээс дэлхийн хамгийн хүчирхэг гүрний гадаад бодлого, стратеги ч гэсэн үүсэж болох олон улсын харилцааны өөрчлөлтөөс хамаарч уян хатан, олон янз байж болдгийг харж болно. “Өөрийгөө тусгаарлах” шинэ гадаад бодлогын хүрээнд олон улсын харилцааны талаар баримтлах гол зарчим нь “бусдын хэрэгт оролцохоос зайлсхийх”, “бүс нутгийн болон үндэстний мөргөлдөөнд зай барих явдал” юм.

Б.Клинтоны засаг захиргаа “сонголттой харилцаа (selective engagement)” гэсэн төрийн бодлого баримталж ирсэн бол өнгөрсөн 4 жилд АНУ-ын БН-либерал консерватив нам сонгуульд ялснаар Ж. Буш олон улсын аюулгүй байдлын асуудлуудаар “тэргүүлэх (primacy)” бодлогыг голлож гэж үзэж болно. Харин ирэх 4 жилд АНУ-ын засаг захиргаа олон талт хамтын ажиллагааны хэлбэрийг ч ашиглаж болзошгүй төлөв цухалзах болжээ. АНУ “тэргүүлэх (primacy)” бодлогын хүрээнд гол төлөв жижиг улсуудын дотоод хэрэгт шууд оролцоод байвал манай их хөршүүдэд үлгэр жишээ болж халдварлаж болзошгүй.

Хүснэгт-2. АНУ-ын Их Стратегийн алсын харгаа (Grand Strategy Visions)

Их Стратеги	Шинэ тусгаарлах бодлого <i>/20 жилиас өмнө/</i> Батлан хамгаалах хамгийн бага реализм (Minimal defensive realism)	Сонголттой харилцаа <i>Клинтон</i> Уламжлалт тэнцвэрт хүчний реализм	Хамтын аюулгүй байдал <i>Горни сонгуулийн хөтөлбөр</i> Либерализм	Тэргүүдэх (Primacy) <i>Буш</i> Нэг талт хамгийн их реализм (Maximal realism unilateralist)
Баримжаалах асуудлууд (Analytical Anchor)				
Олон улсын гол асуудал	Бусдын хэрэгт оролцохоос	Гол хүчүүдийн хоорондох энх тайван	Энх тайван	Ойролцоо өрсөлдөгч гарч ирэх
Дэлхий дээр хүсэж байгаа дэг журам	Хүчний тэнцвэрээс хол байх	Хүчний тэнцвэр	Харицан хамаарал	Ноёрхон (hegemonic)
Цөмийн гэвсгийг хэрэглэх нь (Nuclear Dynamics)	Статус кво-д туслана Supports status quo	Статус кво-д туслана Supports status quo	Түрэмгийлэлд ашиглана (Supports aggression)	Түрэмгийлэлд ашиглана (Supports aggression)
Үндэсний ашиг сонирхлын хүрээ	Явцуу	Аж үйлдвэржсэн Евро-Азвар хязгаарлагдана	Үндэстэн дамжсан	Өргөн
Бүс нутгийн ач холбогдол	Хойд Америк	Аж үйлдвэржсэн Евро-Ази	Дэлхий	Аж үйлдвэржсэн Евро-Ази ба өрсөлдөгчийн нутаг
Цөмийн гэвсэг хураах	Асуудал биш	Ялгавартай сэргийлэх	Ялгаваргүй урьдчилан сэргийлэх	Ялгаваргүй урьдчилан сэргийлэх
НАТО	Гарах	Хэвээр байлгах	Өөрчлөх, өргөжүүлэх	Өргөжүүлэх
Бүс нутгийн мөргөлдөөн	зай барих	Тогтоох; ялгаварлах	Хөндлөнгөөс оролцох	Тогтоох; ялгавартай хөндлөнгөөс оролцох
Үндэстний мөргөлдөөн	зай барих	Тогтоох	Бараг ялгаваргүй	тогтоон барих
Хүмүүжилгийн оролцоо	зай барих	Ялгавартай хөндлөнгөөс оролцох	Бараг ялгаварлахгүй оролцох	Ялгавартай хөндлөнгөөс оролцох
Хүч хэрэглэх	Өөрийгөө хамгаалах	Ялгавартай	Үргэлж	Хүссэнээрээ
Хүчний Байдал	минимум өөрийгөө хамгаалах хүч	Хоёр гол байлдааны театрт байлдах хүч (Two-MRC force)	Сэргийлэн тандах стандартын хүч	Хоёр том театрт олон талт ажиллагаа (A two-power multilateral action)

АНУ-ын Армийн дайны коллеж, 2-1-LS, War and politics; Introduction to Grand Strategy

Тайлбар: Энэ бол АНУ-ын засаг захиргаанаас сүүлийн хоёр зуунд баримталж ирсэн стратегийн үзэл баримтлалын хувилбаруудыг харьцуулан судлах зорилгоор гаргаж ирсэн томъёолол бөгөөд засгийн эрхэнд гарч ирэх эрх баригчдаас хамааран энэхүү стратегийн чиг шугамуудын аль нэг хувилбарыг баримтлах боломжтой хэмээн үзэж байна. /Зохиогч Ч.С./

ОХУ аюулгүй байдлын үзэл баримтлал дээрээ олон жил ажиллаж байгаа ч орчин үеийн шаардлага хангахаар эцсийн хувилбар дэвшүүлж чадахгүй байна.. Ерөнхийдөө их гүрний эрх ашиг нь бодитой байх бөгөөд энэ нь бусад орны эрх ашигтай зөрчилдөж болно, түүнийгээ хүчээр хамгаалах ч болно, Оросын нөхцөлд үндэстэн ястны бүрэн

хэмжээний ардчилал байж таарахгүй гэсэн үзэл бодлууд ОХУ-д давамгайлж байна. Их Оросын үндэсний үзэл, үндсэрхэг салан тусгаарлах үзэлтнүүдийн хоорондын тэмцэл хурцалвал аль аль талаасаа хүч хэрэглэж болзошгүйг Чеченийн хэрэг явдал баталж байна.

Оросын газрын тосны магнат Ходорковскийн хэрэг явдал ЗХУ бутарсанаас хойш тус улсад, улс төр, эдийн засгийн хөгжлийн чиг шугам ээдрээтэй байгааг дахин нотлон харуулав.⁴

Оросын олигархууд явцуу хүрээнд, шударга бусаар явагдсан өмч хувьчлалаас хэр зэрэг юм олж авсан байна төдий чинээ эрсдлийг өөртөө авчрах болов. Путиний засаг захиргааны явуулж буй бодлогоос харахад олигархуудтай тооцоо бодохдоо тунг нь тааруулахгүй бол мөн л эрсдэлд орж болохоор байна. Иймэрхүү дүр зураг ОХУ-д ойрын 10 жилдээ үргэлжилж болзошгүй нь манайд ашиггүй юм.

БНХАУ эдийн засгийн хөгжилдөө ойрын ирээдүйд голлон анхаарах нь тодорхой хэдий ч аюулгүй байдлын талаар Хятадын онолчид орчин үед зарим гүрэн жанжлах дээрэнгүй бодлого явуулснаас бүс нутагт хилийн маргаан, эрдэс баялгийн төлөө тэмцэл өрнөж үндэстэн, шашны зөрөлдөөнөөс шалтгаалан дайн, байлдаан гарна гэж үздэг. Хятадын эдийн засгийн нээлттэй бодлого, улс төрийн хаалттай бодлогын хоорондын зөрчил мэдрэгдсээр байна. БНХАУ-ын эргийн бүс нутаг болон бусад мужуудын эдийн засгийн тэнцвэргүй хөгжил, Тайвань, Өмнөд Хятадын тэнгисийн Параселийн арлууд, Сенкаку арлыг тойрсон хэрэг явдлууд, Түвд, Уйгарын үндэстний цөөнхийн асуудлууд, төрийн албан хаагчдын авилгал, хээл хахуулийн хэргүүд нь Хятадын дотоод дахь ил далд зөрчил, тэмцлийн үндэс болж байна.

ОХУ, БНХАУ-ын дотоод улс төрийн байдалд үндэстэн ястан, шашин шүтлэгийн ил далд зөрчил, үзэл суртал, улс төрийн хуучинсаг болон ардчилсан сэтгэлгээний хоорондын тэмцэл илэрсээр байна.

Өрнөд, орос, их хан үндэсний соёл иргэншилтэй өрсөлдөн өөрийн орон зайг эдгээрээс нөхөн тэлэхийг оролдож буй лалын ертөнц Монголд ойрхон байгаа. Цэргийн мөргөлдөөн тасрахгүй байгаа Ойрхи болон Дундад Дорнодын лалын шашинтай улсуудтай түүх, газар нутгийн шижмээр холбоотой хөрш жижиг Монгол оронд тэнд болж байгаа хямрал мөргөлдөөн нөлөөлөх магадлал өндөр.

Эцсийн эцэст Монголын аюулгүй байдал өөрийнх нь тогтвортой хөгжил, Орос, Хятадтай харилцах харилцааны тэнцвэр, хөршүүдийн дотоод байдал Оросын /үндэстэн байгуулах/, Хятадын/эдийн засгийн шинэчлэлтээс/, АНУ-ын Ази дахь бодлого, манай улсын даяаршлын үе дэх олон улсын байр суурийн өөрчлөлт өрнөлөөр тодорхойлогдоно. Монгол Улс дээрх тогтворгүй байдлын эсрэг ҮАБ-ын үзэл баримтлалд

тусгасан олон арга замуудыг хэрэглэх нь тодорхой бөгөөд энэ нийтлэлд цэргийн арга хэрэглэх үндэслэлүүдийг голлон анхаарлаа.

Манайх шиг жижиг орны хувьд томоохон байтугай жижиг хямрал нь даамжирч улс үндэстний аюулгүй байдал, тусгаар тогтнолд нөлөөлөх хэмжээнд хүрэх магадлал өндөр бөгөөд энэ нь олон шалтаг шалтгаанаас үүсэх боломжтой юм.

Дээрхи сценариудаас харахад эдийн засаг, улс төрийн болон “уламжлалт бус аюул заналхийлэл” буюу үндэстэн дамжсан террорист үйл ажиллагаа, байгаль экологийн гамшгийн аюул нь эцсийн эцэст улс орны тусгаар тогтнолын асуудалд хүрч, ингэснээр цэргийн оролцоог тулгах нь зайлшгүй гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Иймэрхүү нөхцөл байдал өнөөдөр дэлхий дээр хямрал задралтай байгаа олон жижиг улсуудын практик жишээнээс харагдаж батлагдаж байна.

Зэвсэгт хүчнийг шинэчлэх урт, дунд хугацааны тодорхой стратеги, төлөвлөгөөтэй болсноор сонгууль бүрийн дараа Зэвсэгт хүчин хэрэгтэй эсэх, ямар хэлбэр агуулгатай байх талаар маргах, батлан хамгаалах төсвийг зөвхөн хэрэглээний төсөв байлгадаг нөхцөл орчин өөрчлөгдөх нэг гол үндэс суурь болно.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Scenarios- situation, circumstances, development, picture (үзэгдэл, нөхцөл байдал, тоглолт– цагийн байдал)
2. АНУ–ын Армийн дайны коллеж, 2-1-LS, War and politics; Introduction to Grand Strategy
3. Мөн тэнд
4. Маршал Голдман. “Зальхай эзэд залхаг төрийг хуурсан нь”. *Монгол Таймс* сонин, 2004 оны 12 сар.